

ӨГҮҮЛЭЛ

**Т.Бавуудорж: Олзлогдсон япон цэргүүдийн
хумсны толион дээр ханзаар бичсэн
нэр хаягийн тухай****Оохнойн Батсайхан**

Доктор (Sc.D), профессор

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

batsaikhano@mas.ac.mn

Хураангуй: Энэ жил Монгол Улс Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож буй билээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Зөвлөлт Холбоот Улсад олзлогдсон япон цэргүүдээс тодорхой тооны цэргүүдийг Монгол Улсад өгч, ажиллуулж байсан тухай бид мэдэх юм. Харин энэ үед буюу 1945 оны 10 дугаар сараас 1948 оны 2 дугаар сар хүртэл Дотоод явдлын яамны Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба Хорих ангиудыг удирдах газрын даргаар, мөн тус яамны Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Тасрангийн Бавуудорж гуай 1989-90 оны үед дурдатгалаа өөрийн гараар бичиж, над өгсөн юм. Тэрбээр дурдатгалдаа 1930-аад оны Монголын түүхийн ээдрээ бүхий зарим асуудлаар, тухайлбал 1932 оны “лам нарын бослогын” талаар, Өрлөг Жанжсин Дэмидийн тухай, Маршал Чойбалсангийн өөрийгөө илчлэх тушаалын талаар онц сонирхолтой зүйлс бичиж тэмдэглэсэн байдаг. Үүний зэрэгцээ Олзлогдсон япон цэргүүд нутаг буцах болоход Японы олзлогдсон цэргийн Ерөөгийн лагерийн дарга хошууч Иший “тэнд үхсэн цэргүүдийнхээ эрхий хурууг огтлон аваад овог, нэр, нас, нутгийг тэмдэглэн бичиж” авч явсан тухай сонирхолтой зүйлс тэмдэглэснийг энд өгүүлэх болно. Харин 1945 оны 12 дугаар сарын 12-нд Сайд нарын Зөвлөлийн дэргэд байгуулагдсан Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газрын даргаар нь Бадамжавын Сосорбарам ажиллаж байсан байдаг билээ. 1947 оны 11 дүгээр сарын 4-нд Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх газрыг өргөтгөн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Барилгын хэргийг эрхлэх ерөнхий газар болгон байгуулсан байдаг. Энэхүү дурдатгалын эзэн



Т.Бавуудорж бол 1948 оны 2 дугаар сараас 1956 оны 9 дүгээр сар хүртэл БНМАУ-ын Аж Үйлдвэрийн яамны сайдаар ажиллаж байсан хүн юм. Тэрбээр Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу буюу одоогийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын харьяат нэгэн билээ.

Түлхүүр үгс: *Олзлогдсон япон цэргүүд, дэлхийн хоёрдугаар дайн, Т.Бавуудорж, БНМАУ, Япон улс, ЗХУ*

1989 оны сүүлчээр Монголд ардчиллын салхи орж, урьд өмнө бичиж болдоггүй байсан зарим зүйлсийн талаар бичиж эхлээд байсан үе юм. Тэр үед 1920 – 1930-аад онд Монголд болж өнгөрсөн их хэлмэгдүүлэлтийн тухай болон 1950 иад оны намын эсэргүү бүлгийн талаар нэлээд ярьж эхэлсэн юм аа. Тэр давалгаан дунд 1945 оны 10 дугаар сараас 1948 оны 2 дугаар сар хүртэл Дотоод явдлын яамны Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба Хорих ангиудыг удирдах газрын даргаар ажиллаж байсан дараа нь БНМАУ-ын Аж үйлдвэрийн яамны сайд, Сайд нарын Зөвлөлийн Барилга эдийн засгийн комиссын орлогч дарга зэрэг төрийн өндөр алба хашиж байсан Тасрангийн Бавуудорж гуай өөрийн дурдатгалаа авчирч өгсөн юм. Тэр дурдатгалаа “Тасрангийн Бавуудорж миний нам, улсад ажилласан хугацаанд тохиолдож байсан зарим зүйлүүдийн товч дурдатгал” хэмээн нэрлээд цэнхэр өнгийн үзгээр шинэ үсгээр бор өнгийн хавтастай тухайн үед 5 төгрөгний дэвтэр хэмээн нэрлэгдэж байсан дэвтэр дуустал бичсэн байх бөгөөд өөрөө хуучин монгол бичгээр маш сайн бичдэг байсан юм. Т.Бавуудорж гуайн бичсэн эл дурдатгал нь 1989 оны 10 дугаар сарын сарын 6 нд надад ирсэн бөгөөд уг дурдатгалыг ”3 хувь машинаар цохиул” хэмээн манай институтийн хэлтсийн эрхлэгч доктор

Л.Бат-Очир цохолт хийж байсан нь хүртэл хадгалагдан үлджээ. Тухайн үед миний бие МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институтэд эрдэм шинжилгээний ажилтан байсан бөгөөд мөн түүхч, ахмад ажилтан О.Пүрэв гуайн хамтаар Намын ахмад гишүүдийн дурдатгал номын цувралыг хэвлүүлэхээр бэлтгэж байхад надад ирсэн хэрэг. Гэвч бидний бэлтгэсэн Намын ахмад гишүүдийн дурдатгалын 5 дугаар дэвтэр хэвлэгдээгүй бөгөөд учир нь улс орон улс төрийн том эргэлтэнд орж хэвлэхэд шаардлагатай мөнгө олдоогүй билээ. Харин Т.Бавуудорж гуайн дурдатгалаас Олзлогдсон япон цэрэгтэй холбогдол бүхий энэ хэсгийг миний бие 1994 онд Ил Товчоо сонинд Улаанбаатар хотноо нэгэнтээ хэвлүүлсэн юм.

Тэрбээр дурдатгалаа ”Тасрангийн Бавуудорж би Хуучин Засагт хан аймгийн Эрдэнэ Дүүрэгч вангийн хошуу буюу дараа нь Хантайшир уулын аймгийн Дэлгэрхан уулын хошууны эдүгээгийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Цахир даваа хэмээх газар 1915 оны 2 дугаар сарын 13 буюу Хуучин улирлын 16 дугаар жараны харагчин луу жилийн өвлийн адаг сарын битүүнд малчин ард Тасрангийн 4 дүгээр хүү болон төрсөн” хэмээн эхэлжээ.

Уг дурдатгалын эхэнд 1932 оны “эсэргүү бослого”-ын талаар “1932 оны эсэргүү бослого гарсан аймгуудын

намын байгууллагуудыг тарааж, түр хороод гэж нэртэй намын хороо байсан юм”, ардууд олон асуулт тавьдаг байсны заримыг дурьдвал: “Лам нарыг сүм хийдээс нь хөдөө албаар гаргах буюу албадан хар болгох уу?”, “Хамтралд орохдоо өгсөн малаа зүсээр нь юм уу, тоогоор нь буцааж авч болох уу”, “Хүүхдээ тэнхимээс авч лам болгож болох уу”, “Мал олонтой хүнийг нударган гэж ад үзэхээ болих уу?” гэх зэрэг асуултуудыг тавьж байсныг тэмдэглэсэн онц сонирхолтой бөгөөд тухайн үеийн үнэн байдлыг олж тогтооход чухал мэдээлэл агуулсан сурвалж мөн хэмээн үзэж болно. Мөн цааш нь дурдатгалд их хэлмэгдүүлэлтийн талаар: “1937 оны 9 дүгээр сард шиг санагдаж байна. Нэг өдөр дарга нарт өнөө шөнө хээрийн сургуультай хэдэн цагт явах тухай тусгай мэдэгдэнэ. Байрандаа бэлэн байцгаах хэрэгтэй гэж тушаал өгсөн... тэнд лагерын бүх ангиудын дарга нар цугларсан байлаа...”, “1937 оны 10 дугаар сард хэсэг “эсэргүү” нарыг шийтгэх улсын дээд шүүхийн нээлттэй хурал тэр үеийн төв цэнгэлдэх хүрээлэн /Бөмбөгөр ногоон/-д болсон... “, “хурлын зарим байцаалтыг радиогоор нэвтрүүлдэг байсан бөгөөд түүнийг сонсохоор цэнгэлдэхийг тойрон олон зуун хүн өдөржин зогсдог байсан”, “биеэ сайн дураар илчилбэл ял зэмлэлгүй өршөөл үзүүлнэ гэсэн 221 тоот Маршалын тушаалын” тухай “Маршал цагруугаа хараад би та нарт 5 минутын дараа хугацаа өгье” гэхэд “цугларсан хүмүүс чиг чимээгүй болж амьсгал нь дуудаж байсан бөгөөд нэг ч хүн суудлаасаа хөдөлсөнгүй, үг ч хэлсэнгүй, одоо ангидаа очицгоо” гэж хэлсний дараа “бүх хүмүүс бараг уралдах шахам хаалгаар багтаж ядан

гарцгааж” билээ хэмээн дурссан байна. Бавуудорж гуайн өөрийн биеэр туулсан амьдралаа ямар нэгэн хэтрүүлэггүй, бодит байдлаар бичсэн нь түүхэн үнэнийг тодруулахад чухал сурвалж болох нь дамжиггүй юм.

Энд дурдагдаж буй “түр хороод гэж нэртэй намын хороо” гэсэн үгс бол чухамдаа Намын хороодын ихэнх нь 1932 оны бослогыг дэмжиж байсныг илтгэж буй бөгөөд тиймээс өмнө байсан намын хороодыг бүгдийг татан буулгаж, түр хороо байгуулсаныг хэлж буй хэрэг юм. Түүгээр ч үл барам, намын ихэнх гишүүд бослогыг дэмжсэн байх магадлалтай байдаг. Учир нь, бослогын дараа намын олон гишүүдийг “намын цэвэрлэгээ” нэрийн дор намын гишүүнээс байлгаж, намын хороодыг татан буулгаж, тийнхүү түр хороо байгуулсан байдаг.

Тэрбээр дурдатгалдаа Озлогдсон Япон цэргүүдийн талаар хэрхэн өгүүлснийг дор бүрэн эхээр нь толилуулья.

“Миний хүсэлтээр 1944 онд намайг МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Сүхбаатарын нэмэржит Намын дээд сургуульд оруулсан юм. 1945 оны намар 10 сарын сүүлээр Төв Хороон дээр дуудав. Цэдэнбал даргын тасалгаанд оруулав. Тэнд ямар хурал болж байсныг мэдэхгүй Чойбалсан-гаас бусад бүх дарга нар байсан шиг санагдаж байна. Чамайг Дотоод явдлын яамны Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба Хорих ангиудыг удирдах газрын даргаар томилно гэв. Би тэр ажлыг мэдэхгүй сургуулиа төгсөө гэж гуйв. Сүрэнжав дарга; Одоо Японы олзлогдсон цэргүүд ирнэ тэднийг Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд дээр байрлуулна. Тэдэнтэй олон улсын хэлэлцээр хуулийн дагуу хоригдолтой

адил харилцаж болохгүй. Зөвлөлтөд олзлогдсон цэргийн байгууллагад дан намын ажилтан голдуу хүмүүсийг тавьдаг юм байна. Бид Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газрыг байгуулж, даргаар нь Хотын намын хорооны дарга Сосорбарамыг томилсон. Одоо тэдний байнга сууж ажиллах газрыг засан хүмүүжүүлэх газар гэж тогтсон тул даргаар нь чамайг томилохоор шийдэж байна. Чамд 3 үүрэг өгнө. Нэгд Чи Сангийн аж ахуйн трестийн дарга байсан тул одоогийн лагеруудыг ирээдүйд САА болгох бэлтгэлийг ханга, хоёрт, Дотоод яаманд хуулийн мэргэжилтэй сургагч нарын тусламж заавраар олзлогдсон цэргүүдтэй яаж харилцах тухай хууль дүрмийг судалж зөв харьцаж байх, Гуравт, чи өөрөө Халх голын байлдаанд оролцсон учир Японы цэргийн ерөнхий байдлыг бас бага сага мэддэг гэж тэр талыг харгалзсан юм. Чи саяхан аймгийн намын хорооны дарга байсан болохоор бас тэр талаас нь харсан юм гэсэн шиг санагдаж байна. Би ер нь чадахгүй байх гэж хатуу бодоод бас хажууд нь аймаар ч юм шиг санагдаад дахин сургуулиа төгсгөхийг гуйсанд энэ асуултыг (намайг томилох тухай) Маршал (Х.Чойбалсанг хэлж байна. – О.Б) зөвшөөрсөн юм гэв. Би ч хэлэх үг олдсонгүй, тэндээсээ Дотоод явдлын яам руу тэр яамны сайд байсан генерал Шагдаржавтай хамт гарч уул ажлыг хүлээн авсан юм. Улаанбаатарт байсан Японы олзлогдсон цэргүүдийн барьсан объектууд гэвэл Засгийн газрын ордон, Элдэв Очир кино театр, одоогийн хотын захиргааны байр, Гадаад явдлын яам, Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуулийн цогцолбор, Дуурь бүжгийн театр зэргүүд болно” хэмээн Т.Бавуудорж гуай дурдатгалдаа бичээд

цааш өгүүлэхдээ анх япон цэргүүд Монголд ирэхдээ ямар байдалтай байсан хийгээд буцах болоход Исий хэмээх генерал нас барсан япон цэргүүдийн нэр, нутаг усыг эрхий хуруунийх нь толион дээр бичиж авч явсан тухай баримтыг доорхи байдлаар бичжээ.

Тэрбээр дурдатгал дотроо ”Хумсны толион дээр бичсэн нэр хаяг” хэмээх жижиг гарчиг өгч, түүндээ ”Японы олзлогдсон цэргүүд нь Ерөө, Зүүн болон Баруун Хараа, Бороо зэрэг хорих лагерууд дээр байсан бөгөөд тэд ирэхдээ урьд манай оронд огт үзэгдээгүй янз бүрийн халдварт бөөсний болон эргэдэг хижиг зэрэг өвчнөөр маш олноор өвчилж байрын болон хоол унд эмнэлгийн хангалтгүйгээс олноор нас барах явдал ерийн үзэгдэл байв. Ялангуяа анх ирсэн 1945-1946 оны эхний улиралд их байлаа. Хөдөөгийн лагерт байсан Японы олзлогдогчид сангийн аж ахуйнуудад газар тариалангийн ажил хийдэг байсан юм. 1946 оны эцэс 1947 оны эхээр хөдөө байсан японуудыг Улаанбаатар хотод ирүүлэх тушаал дээрээс гарсан. Энэ нь тэд нутаг буцахаар Зөвлөлтөд (Зөвлөлт Холбоот Улсыг хэлж байна –О.Б) цугларан нэгдэх ёстой байжээ. Бусад лагеруудын адил Ерөө лагерт байсан японууд хотод иржээ. Тэдний дарга нь хошууч Исий гэдэг их соёлтой хижээлдүү хүн байсан юм. Ирсэн японуудын авч явсан юманд манай газрын гүйцэтгэх хэлтсийн аппаратын хүмүүс үзлэг хийдэг байлаа. Тэр хэлтсийн дарга хошууч Тэрбиш гэдэг хүн над дээр нэг орж ирэхдээ миний ширээн дээр нэг бага шиг цагаан давуу хүүдийтэй юм авчирч тавьлаа. Тэгээд та наадхаа үзээч гэв. Би учрыг нь мэдсэнгүй, амыг нээж

харвал тослог бор өнгөтэй, гялгар талд нь хар юмаар эрээчсэн юмнууд байв. Нэгийг аваад үзсэн чинь (толион дээр нь) хятадаар (Т.Б гуай хятадаар бичсэн гэж эхлээд бодсон хэрэг уг нь японоор бичсэн байжээ) юм бичсэн хүний эрхий хурууны мах нь хатсан яс байв. Над эвгүй сэжиг төрж буцааж уутанд нь хаяад энэ чинь чи юу хаанаас олоод ирэв гэж Тэрбишээс асуув. Тэр ”Японы олзлогдсон цэргийн Ерөөгийн лагерийн дарга хошууч Исий тэнд үхсэн цэргүүдийнхээ эрхий хурууг огтлон аваад овог, нэр, нас нутгийг тэмдэглэн бичиж ингэж хадгалдаг юм байна. Одоо нутаг буцахдаа гэр оронд нь өгөх юм гэнэ. Бид юмы нь нэгжиж байхдаа олсон тэгээд танд авчирлаа” гэв. ”Исий хаа байна” гэхэд ”Япон офицерүүдийн байранд бий. Чангаланд (карцер) оруулах санаатай байна” гэлээ. Япон цэргийн лагер бүрт Өвөр Монголоос Японд цэргийн сургууль хийж япон хэл сайн эзэмшсэн Дэмчигдонров вангийн цэргийн албан хаагчид орчуулга, хэлмэрч хийдэг байсан юм. Би Исийгийн хэлмэрчийг дуудуулж ямар учиртай болохыг асуухад тэр ”Манай ноён хошууч Исии сан нас барсан хүмүүсийн баруун гарын эрхий хурууг огтлон авч тэр хүний нэр нас нутаг хэзээ ямар өвчнөөр үхсэнийг тусгай үсэг тоогоор тэмдэглэн авч хадгалж байгаа. Хэзээ нэгэн цагт нутаг буцахдаа ар гэрийнхэнд нь өгөх юм гэнэ билээ. Энэ бол Эзэн Хаандаа өргөсөн тангаргаа биелүүлж байгаа Наран улсын цэргийн дарга нарын ёс юм гэж над хэлж байсан” гэв. Би Тэр Исийг одоогоор чангаланд хийхээ азнаж бай гэж Тэрбишд хэлээд тэр хүүдийтэй хуруунуудыг аваад Дотоод Явдлын яаманд олзлогдсон цэргийн талаар зөвлөгөө өгдөг мэргэжилтэн

(зөвлөхийн орлогч) хурандаа Дементив дээр авч очоод болсон явдлыг тайлбарлан ярив. Тэр хэлэхдээ; ”Энэ бол манайхаар нөгөө бидний ярьдаг ”эх оронч” үзэл, тэд ч цэргийн хүмүүс, бид ч цэргийн хүмүүс, Хошууч Исии захирсан цэргүүдийнхээ төлөө ганц Японы дайчдын түрэмгий бодлогыг биелүүлэхэд их бууны мах болгон хувиргах төдийгөөр хязгаарлаагүй цэргийнхээ төлөө тэдний эцэг эхийн, эхнэр хүүхдийн төлөө бодсон энэрэнгүй сэтгэл юм. Түүнийг энэ талаар буруушаах хатуу чангаланд хийж болохгүй. Энэ хуруунуудыг нь буцааж өг” гэлээ. Би эргэж ажил дээрээ ирээд Тэрбишт хурандаа Дементивийн хэлсэн зөвлөмжийг дамжуулж Исийг хэлмэрчтэй нь дуудан ирүүлж амар мэндийг асуугаад ”манай нөхөд танай энэ зүйлийн учрыг олоогүй, манайд ийм заншил байдаггүй болохоор над авчирч өгсөн юм. Энэ танд хэрэгтэй юм бол та үүнийгээ ав” гэж хэлээд түүнд өгөв. Тэр суудлаас босож ”Би цэрэг хүн, Эзэн хаандаа цэргээ захирахдаа эцэг эхий нь бас орлоно гэж тангарагласан. Энэ цэргүүд миний захиргаанд байгааг тэдний ойрын хүмүүс мэдэж байгаа. Тэдний нэг нутгийн цэргүүд одоо амьд нутагтаа буцах гэж байна. Би цэргийн хүн тангаргаа биелүүлж яваа хүн. Та ч цэргийн хүн тангаргаа биелүүлэх гэж боддог байх. Эрхэм ноён хошууч (би хошууч байсан юм хэмээн Т.Бавуудорж гуай тэмдэглэжээ –О.Б) танд чин сэтгэлээсээ талархаж” гэж байна гэж хэлмэрч нь над орчуулж өгсөн. (Энэ нь одоо санаанд үлдсэн зүйл хэмээн Т.Бавуудорж гуай тэмдэглэсэн байна –О.Б). Тэр Исий их удаан бараг 5 минут орчим юм ярьсан. Би түүний үгийг бичиж аваад

(Дементивийн даалгавраар) цохиулан дахин хэлмэртэй нь ярьж шалгаад Дементивд монгол хэл дээр өгсөн. Тэр орос болгон орчуулж аваад над монгол эхийг өгнө гээд өгөө ч үгүй, би ч авъя гэж хөөцөлдөөгүй. Тэгээд хошууч Иси над ёслол толгойгоо бараг газар хүргэх шахам бөхийн ёслоод хуруунуудаа хүүдийтэй нь аваад явсан санагдана.

Тэгээд японууд ч явах болсон. МАХН-ын 11 дүгээр их хурлын бэлтгэл ажил - намын анхан ба дунд шатны байгууллагуудын тайлан сонгуулийн хурал болж, тэр үеийн Дотоод явдлын яамны намын хороог өргөтгөж Намын Төв Хороонд шууд захирагдах болгосон бөгөөд 1948 оны 1 дүгээр сард мөн намын бага хурлаар намайг Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар сонгож урдах ажлаас чөлөөлсөн болно” гэжээ.

Энэ бол Т.Бавуудорж гуайн дурдатгалд буй Зөвлөлт Холбоот улсаар дамжин Монголд очсон Олзлогдсон япон цэргүүдийн үйл ажиллагаанд холбогдох нэг л мэдээ юм. Үнэндээ 1990 ээд он гартал Монголд Олзлогдсон япон цэргүүдийн тухай бүү хэл энгийн япон хүмүүсийн талаар ч ярих хориотой шахам байсан юм. Иймээс Монголд япон цэргүүдийн байсан үеийн үйл ажиллагааны талаарх түүхэн бодит үйл явцыг сайтар мэдэх хүмүүс цаг хугацааны эрхээр ховор болоод байсан юм. Тиймээс Т.Бавуудорж гуайн эл дурдатгал бол нэг талаас тухайн үед алба хашиж явсан хүний сэтгэлд шингэж үлдсэн зүйлс төдийгүй орчин цагийн бидэнд түүхийн үнэт эх сурвалж болох нь дамжиггүй хэмээн санана. Мэдээжийн хэрэг хүмүүний амьдралд өөрийн амраг садан, аав, ах, үр хүүхдийнхээ хувь зохиолын талаар санаа зовнин,

сэтгэлийн мухарт мэдээ сэжүүр эрэлхийлэн явах нь хүн байхын утга учиртай салшгүй холбоотой тул энд гарч буй мэдээ, мэдээлэл Олзлогдсон япон цэргүүдийн ар гэр хийгээд япон зон олны сэтгэлд нэгийг өгөх аваас өчүүхэн судлаачийн хүсэл биелэх нь тэр болой.

Одоо харин Японы цэргүүд Монголд анх хэрхэн ирсэн талаар нэлээд сонирхолтой архивын баримт Монгол Улсын архивт хадгалагдаж байгааг олж үзсэн тул Япон улсын анд нөхөд лүгээ хуваалцахыг хүссэн юм.

Олзлогдсон япон цэргүүд лүгээ холбогдох удаах баримт бол Эдүгээ МАХН-ын архивт хадгалагдан буй ”Олзлогдсон цэргүүдийг байрлуулах тухай” болон ”Олзлогдсон цэргүүдийн хөдөлмөрийн хүчийг ашиглаж Улаанбаатар хотын барилгыг өргөтгөх тухай” БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл ба МАХН-ын Төв Хорооны 1945 оны 10 дугаар сарын 4 ны болон 11 дүгээр сарын 2-ны өдрийн хамтарсан 72/59 ба 79/62 дугаар хурлуудын тогтоолууд болно.

1945 оны намар ЗХУ-ын эрх мэдэл бүхий хүмүүсээс Монголын Төр засгийн удирдагчдад Зөвлөлтийн Улаан армийн олзолсон зарим Япон цэргүүдийг Монголд байршуулах талаар мэдэгдсэн байна. Энэ мэдээг авуут Монголын Засгийн газар тэр даруй Олзлогдсон цэргүүдийг байрлуулах тухайн ажлыг эрхэлсэн Засгийн газрын комисс байгуулсан байна. Зарим эх сурвалжаар эхлээд Монголд 20 мянган олзлогдсон Япон цэрэг илгээх тухай яригдсан боловч чухамдаа бол 12 мянга гаруй олзлогдсон япон цэргүүдийг Монголд ирүүлсэн байна. Харин Монголын Засгийн газрын Комиссоос Олзлогдсон

цэргүүдийг байрлуулах талаар авч хэрэгжүүлсэн бэлтгэл ажлаас үзэхэд дор хаяад 15 мянган гаруй олзлогдсон цэргүүдэд хүлээн авах байр бэлтгээд дээр нь нэмэн байр олох ажил хийж байснаас үзвэл дээр дурдсан 20 мянган олзлогдсон Япон цэрэг ирүүлэх мэдээ Монголд ирсэн хэмээн үзэж болох юм. Үнэндээ ийм олон тооны олзлогдсон япон цэргүүдийг шууд хүлээн авахад Монголын хувьд бас тийм ч амар байсангүй тул нэлээд их бэлтгэл ажил хийх шаардлагатай болсон байна. Иймээс Монголын Засгийн газраас багагүй арга хэмжээ авч олзлогдсон цэргүүдийг хүлээн авах уг ажлыг богино хугацаанд хэрэгжүүлсэн байх бөгөөд эдүгээ харвал хэд хичнээн япон цэрэг Монголд ирээд хаана байрлаж байсан тухай мэдэж болох юм.

1945 оны 10 дугаар сарын 4 ны өдөр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл ба МАХН-ын Төв Хороо хамтран хуралдаж, "Олзлогдсон цэргүүдийг байрлуулах тухай" 72/59 тоот тогтоол гаргасан байна. Тэрхүү тогтоолд Олзлогдсон цэргүүдийг байрлуулах тухайн ажлыг эрхэлсэн Засгийн газрын комиссын дарга н.Лувсангийн илтгэлийг сонссон тухай тэмдэглээд Тус комиссын санал болгосон олзлогдсон цэргүүдийг суулгах хуаран болгон түр ашиглах дурдсан байшин барилгуудыг түр шилжүүлэн авахыг зөвшөөрсөн байна. Засгийн газрын комиссын тогтоолд дурдсан бүх байшин барилгыг даруй Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газраас хүлээн авч, тэдгээр байшин барилгыг олзлогдсон цэргүүдийг суулгах хуаран болгон хэрэглэх тухайн төлөвлөгөөг долоо хоногийн дотор гаргаж засварлах үүргийг Дотоод яамны сайд н.Шагдаржавт

үүрэг болгосон байна. Мөн түүнчлэн Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газрын орон тоог тогтоон, хоёр хоногийн дотор түүнийг сайн бэлтгэлтэй ажилтнаар хангах байгуулахыг Дотоод яамны сайд н.Шагдаржавт даалгасан байна. Чухамдаа эл үүргийн дагуу бидний мэдэх дээрх дурдатгалаа үлдээсэн Тасрангийн Бавуудорж гуай уг албанаа томилогдсон хэрэг ажээ. Ийнхүү Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газрыг байгуулж бүрдүүлэхийн сацуу олзлогдсон цэргүүдийг байрлуулах орон сууцыг нэмэн олох ажлыг үргэлжлүүлсээр байжээ. Дээр дурдсан Олзлогдсон цэргүүдийг байрлуулах талаар байгуулсан Засгийн газрын комиссын 1945 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 3 дугаар хурлын тогтоол нь Олзлогдсон япон цэрэг хүлээн авахын өмнөх Монголын байдлыг нэлээд тодорхой харуулах төдийгүй 12 мянган олзлогдсон цэргийг хүлээн авах талаар хэр зэрэг хүчин чармайлт тавьсаныг ч бас харж болох тул уг тогтоолыг эхээр нь хүргэв. Та бүхний оюун ухаан шүүн тунгаах буй за.

"Олзлогдсон цэргүүдийг байрлуулах талаар байгуулсан Засгийн газрын комиссын 1945 оны 10 дугаар сарын 3 ны өдрийн 3 дугаар хурлын тогтоол

Олзлогдсон цэргүүдийг байрлуулахаар байшин барилгуудыг шалган үзээд Засгийн газрын комиссоос тогтоох нь;

Нэг. Олзлогдсон цэргүүдийг нэн даруй байрлуулах талаар

1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот дахь цэргийн гарашт 500 хүн ба мөн зам барилгын хэргийг эрхлэх газрын харьяа барилгад

- 100 хүнийг тус тус суулган ашигласугай.
2. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хот дахь Булигаарын завод ба гар үйлдвэрийн артелийн сууцыг авч 300 хүнийг байрлуулан суулгасугай.
 3. Ерөөгийн модны заводын сууцыг түр авч 100 хүнийг байрлуулсугай.
 4. Зүүн булаг дахь Сангийн аж ахуйн гэр ба барилгад 150 хүн, Энхтал ын сангийн аж ахуйн гэр ба барилгад 100 хүн, мөн Жаргалантын сангийн аж ахуйн гэр ба барилгад 400 хүнийг тус тус суулгаж бүгд 650 хүнийг сууцаар хангасугай.
 5. Олзлогдсон цэргүүдийг Улаанбаатар хотноо хүрэлцэн ирмэгц Махкомбинат дээр хоригдол ажилчны сууж буй газар байрыг суллаж түүнд 200 тооны олзлогдсон цэргүүдийг суулгасугай.
Мөн махкомбинат дээр байгаа банзан саравчид 100 тооны олзлогдсон цэргүүдийг суулгахын тулд түүний дотор талд эсгий хийж, зуух тавих зэргээр дулаалах ажлыг нэн даруй хийж гүйцэтгэхийг махкомбинатын барилгын хэргийг эрхлэхэд даалгахаас гадна түүнд хэрэглэгдэх түрээвчин метр эсгийг аж үйлдвэрийн комбинатаас тавин олгосугай. Үүнийг нэгэн зэрэгцээгээр 150 тооны олзлогдсон цэргийг суулгахын тулд 32 тасалгаат туйпуун сууцын засварыг дуусгаж суллахыг махкомбинатын барилгын хэргийг эрхлэх газарт үүрэг болгосугай.
 6. Сүхбаатарын сургуулийн сууц байшинд 600 хүнийг суулгахын тулд уул байшинг Эрүүлийг Хамгаалах Яамны мэдлээс авч Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газраа түр шилжүүлэн өгсүгэй.
 7. Улаанбаатар хотод Гар үйлдвэрийн эдийн холбооны клуб ба мөн нэгдүгээр артелийн клубийг тус тус гаргаж, нэгдүгээр байшинг засварлан 150 хүнийг суулгах хуаран болгох ба мөн хоёрдугаар байшинг мөнхүү артелийн конторын хамтаар засварлан 130 хүний суух хуаран болгохын тулд Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газарт түр шилжүүлэн өгсүгэй.
 8. Шүдэнзний фабрикийн нэгэн хагаст уул үйлдвэрийг багтаах ба нөгөө хагасыг хуаран болгон засварлаж 300 хүнийг суулгахын тулд Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газраа түр шилжүүлэн өгөхийг Аж үйлдвэрийн яамны сайд н.Гомбожавт даалгасугай.
 9. Аж үйлдвэрийн комбинатын клубыг хааж, 500 хүний суух хуаран болгон хэрэглэхээр Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газарт түр шилжүүлэн өгөхөөс гадна мөнхүү клубын засварыг түргэн хугацаанд дуусгахыг комбинатын дарга н.Гомбод үүрэг болгосугай.
 10. Дор дурдсан байшин барилгуудыг түр ашиглуулахаар тус улсын Засгийн газраа шилжүүлэн өгөх тухай 17

- дугаар армийн цэргийн зөвлөл хүсэх, Үүнд;
- а. Хужирбулан дахь байр 7, хоёр давхар байшин 1, мөн гуанз болон бас бус жижиг сууц ба аж ахуйн барилгуудаас бүрдсэн хуаран (Үүнд 3300 хүртэл хүнийг байрлуулж болно)
 - б. Ардын хувьсгалт цэргийн Туйпуун заводын дэргэдэх сууц ба клуб (Үүнд 600 хүртэл хүнийг байрлуулж болно)
 - в. Амгаланбаатар хот дахь 1200 хүнийг байруулж болохуйц газар байр 2
 - г. Улаанбаатар хотын Гандан дахь 250 хүртэл хүнийг суулгаж болохуйц дүнзэн байшин өөр болой.
11. Энэхүү тогтоолын 10 дугаар зүйлд дурдсан байшин барилгуудыг шилжүүлэн олгосон тухай 17 дугаар армийн цэргийн зөвлөлийн шийдвэрийг хүлээн авмагц автомашины ажилчдыг хоёрдугаар кино театрын байшингаас нүүлгэн Гандах дахь байшинд оруулаад 2 дугаар кино театрын байшинг 600 хүнийг суулгах хуаран болгон хэрэглэхээр Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газрын мэдэлд шилжүүлэн өгсүгэй. Эл хоёрдугаар кино театрын байшингийн 2 дугаар давхар ба бусад байрнуудад сууж буй айлуудыг нэн даруй нүүлгэн гаргаж, өөр газар оруулахыг Тээврийн яамны сайд н.Намсрай, Урлагийн хэргийг эрхлэх газрын дарга н.Болд нарт үүрэг болгосугай.
12. Модон заводын хуучин жолооч нарын сургуулийн байшингийн засварыг хурдан дуусгаж 600 хүнийг суулгах хуаран болгохыг аж үйлдвэрийн яамны сайд н.Гомбожавт үүрэг болгосугай.
13. Нүхтийн аман дахь бүх зуслан ба бусад аж ахуйн долоон байшин барилгыг 100 хүний суух хуаран болгон хэрэглэхээр.

Хоёр. Олзлогдсон цэргүүдийг 2 дугаар ээлжинд байрлуулах талаар

1. Цэнбэ (тоноглолын) фабрикийн 1100 дөрвөлжин метр талбайтай том барилга ба түүнтэй залгасан 2 тасалгааг 100 –1000 хүний суух хуаран болгон хэрэглүүлэхээр Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газрын мэдэлд шилжүүлэн өгсүгэй. Энэхүү байшингаас 60 дөрвөлжин метр талбайг ... (уг эхэд зай орхисон байв О.Б) уул фабрикийн мэдэлд үлдээсүгэй.
2. Олзлогдсон цэрэг 250 хүнийг суулгах хуаран байгуулахын тулд Гар үйлдвэрийн 13 дугаар артелийн хашааг бүх байшин барилгуудын хамтаар Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газарт шилжүүлэн өгч түр ашиглуулсугай. Энэхүү хашаанд сууж буй гар үйлдвэрийн ажилчны гэр бүл 3 г нүүлгэж өөр газар оруулахыг Гар үйлдвэрийн дээд Зөвлөлийн дара н.Надмидад даалгасугай.
3. Соёлын ордон -д байгаа бүх байгууллагуудыг нүүлгэн гаргаж бүрнээ суллаад түүнийг 500 хүний суух

- хуаран болгохоор Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газрын мэдэлд шилжүүлэн өгсүгэй.
4. Улсын дээд сургуулийн шинэ байшингийн 1 дүгээр давхарыг энэ он 11 дүгээр сарын нэгний наана дуусган 800 хүний суух хуаран болгох ажлыг Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газартай хамтран гүйцэтгэхийг Дотоод яамны барилгын хэргийг эрхлэх газарт даалгасугай.
 5. Туйпуун сууц ба халуун усны газрын барилгыг үргэлжлүүлэн хийж туйпуу сууцыг 500 хүн ба халуун усны газрыг 200 хүний тус тус суух хуаран болгохыг Махкомбинатын барилгын хэргийг эрхлэх газраа үүрэг болгохоос гадна энэхүү барилгад хэрэглэгдэх туйпууны барилгын материалыг нэн даруй тавин олгож тэдгээр барилгыг дуусгах хугацааг заан тогтоохыг Улсын төлөвлөгөөний газрын дарга н.Жагваралд даалгасугай.
 6. Дор дурдсан (уг эхэд зай орхисон байв О.Б) ажлыг гүйцэтгэх тухай Гар үйлдвэрийн дээд зөвлөлийн дарга н.Надмидад даалгах нь;
 - а. Гар үйлдвэрийн хүүхдийн цэцэрлэгийн барилгыг түргэн дуусгаж 400 хүнийг суулгах хуаран болгохоор Олзлогдсон цэргүүдийн лагерийн удирдах газраа шилжүүлэн өгсүгэй.
Энэхүү барилгыг дуусгах хугацааг заан тогтоохыг Улсын төлөвлөгөөний газрын дарга н.Жагваралд даалгасугай.
 - б. Хоёрдугаар артелийн клубийн барилгыг 3 долоо хонгийн дотор дуусгаж, түүнд 250 хүний суух хуаран байгуулахаар Олзлогдсон цэргүүдийн лагерийн удирдах газраа түр шилжүүлэн өгсүгэй.
 7. Намын Төв Хороо ба Үйлдвэрчний Төв Зөвлөлийн билд (хуучин гараш)-ийг суллаж түүнд 600 хүний суух хуаран байгуулахаар Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах гарын мэдэлд түр шилжүүлэн өгсүгэй.
 8. Улаанбаатар хотын өмнөд талаар байгаа бүх гараш (Холбооны яамны хуучин гараш)ын байшин барилгыг Улсын сангийн аж ахуйн трестийн мэдлээс авч, Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газарт шилжүүлэн өгөөд түүнд их засварыг хийлгэж 500 хүний суух хуаран болгосугай.
Үүний нэгэн зэрэгцээгээр өөр байшин барилгуудад сууж буй Цэргийн ангийг өөр газар шилжүүлэн өгөх тухайн хүсэлтийг 17 дугаар армийн Цэргийн Зөвлөлийн өмнө тавьсугай.
 9. Аж үйлдвэрийн комбинатын өмнө байгаа Цагаан сүмийн бүх байшин барилгыг 300 хүний суух хуаран болгохоор Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газраа түр шилжүүлэн өгсүгэй.
Эдгээр байшин барилгыг нэн даруй суллахыг Аж үйлдвэрийн

яамны сайд н.Гомбожавт даалгасугай.

Гурав. Барилгын материалыг бэлтгэх Олзлогдсон цэргийг байрлуулах лагериудыг байгуулахын тулд дор хавсаргасан жагсаалтын ёсоор улсын албан байгууллагуудаас 200 гэрийг дайчлан авч Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газар түр шилжүүлж өгсүгэй.

Дөрөв. Сэлбэ дэх Амралтын газрыг хааж, түүний бүх байшин барилгыг госпитал байгуулахаар Олзлогдсон цэргийг лагериудыг удирдах газрын мэдэлд түр шилжүүлэн өгсүгэй.

Тав. Энэхүү дээр дурдсан бүх байшин барилга ба гэрүүдийг Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газар түр шилжүүлсүгэй.

Зургаа. Олзлогдсон цэргүүдийг суулгах хуарангуудыг байгуулахаар түр шилжүүлэн өгч байгаа дээр дурдсан байшин барилгад жижиг засвар хийж, сэлбэх ажлын төлөвлөгөөг нэн даруй зохиож Олзлогдсон цэргүүдийг хүрэлцэн ирмэгц уул ажилд даруй оруулан ажиллуулахыг Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газарт үүрэг болгосугай.

Комиссын дарга

Лувсан

Гишүүд:

Шагдаржав

Цэнд

Сосорбарам”

хэмээжээ.

Олзлогдсон япон хүмүүсийн хүчийг юунд ашиглаж байсан хийгээд тэдний

тусламжтайгаар Монголын хаана ямар ямар барилга байшин сүндэрлэж боссон ч мэдэж болох талтай юм аа. Харин Олзлогдсон Япон цэргүүдийн хүчийг ашиглаж Улаанбаатар хотноо баригдсан барилга байшингууд нь өмнө нь нэгэнтээ эхэлсэн байсан буюу эсвэл эхлэхээр төлөвлөгдөөд байсан байна. 1935 онд БНМАУын Ардын Сайд нарын зөвлөлийн хурлаар ”Улаанбаатар хотын байдлыг хөгжүүлэх өргөн комисс” байгуулагдаж, уг комиссоос Улаанбаатар хотыг нэгдсэн зураг төлөвлөгөөтэй хөгжүүлэх анхны төслийг 1938 онд гаргажээ. Тэрхүү комиссын боловсруулсан уг төлөвлөгөөнд ”хотын тэр үед байгаа хэлбэр дүрс ба байгуулалтын журам нь эрт цагаас эмхэтгэгдсэн бодлого төлөвлөгөөгүй хэн этгээдийн дур саналаар эрэмбэ зарчимгүйгээр байгуулагдсан бөгөөд түүнийг боловсон байдал журамд бүрэн дүүрнээр оруулж шинэтгэн засах гэдэг бол ихээхэн хүнд хүчир ажил болохыг харгалзаж нийслэл хотыг аажмаар өөрчлөн сайжруулах” бодлогыг тавьсан байна. Дурдсан төлөвлөгөөнд Улаанбаатар хотноо шинэ барих барилгуудыг нарийн төлөвлөгөөтэй барихаар заасан байсан нь чухам цагаа олсон хэрэг байлаа. Хотод ”шинээр барих барилгууд нь 4.2 хавтгай дөрвөлжин км газрыг хамарсан бөгөөд гол нь Зүүн Сэлбийн горхиноос баруун тийшх хотын төв хэсгийг оруулсаны дотор Сүхбаатарын нэрэмжит талбайг хотын төв, мөн энэ талбайн өмнө захыг дайрч гарах консулын дэнжээс баруун зах хүрэх замыг гол гудамж болгохоор” үндэслэн бодож, түүнд хуучин том жижиг 34 гудамжийг засахаар хамааруулсан байна. ”Төв талбайд Засгийн газрын барилга, Улсын төв

театр, Дотоод яамны орон сууц, Холбооны барилга, Лениний нэрэмжит клуб, бусад барилгыг оруулах, мөн талбайгаас Туулын гол орох гудамж гаргахаар” төлөвлөсөн байна. Чухамдаа Улаанбаатар хотыг сайжруулах энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэнд Олзлогдсон япон цэргүүд ихээхэн хувь нэмэр оруулж, Улаанбаатар хотын өнөөгийн төв талбайн дүр дөрх 1940 оод оны сүүлч, 1950 иад оны эхээр бий болсон хэмээлтэй. Монголын Засгийн газраас тухай үед Олзлогдсон япон цэргүүдийн хүчийг юунд ашиглахаар төлөвлөснийг доорх архивын баримтаас харж болох юм.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл ба МАХН-ын Төв Хорооны 1945 оны 11 дүгээр сарын 2 ны өдрийн хамтарсан 79/62 дугаар хурлын тогтоол

Олзлогдсон цэргүүдийн хөдөлмөрийн хүчийг ашиглаж Улаанбаатар хотын барилгыг өргөтгөх тухай

Олзлогдсон цэргүүдийн хөдөлмөрийн хүчийг барилга, барилгын үйлдвэр болон Улаанбаатар хотыг сайжруулах ажил дээр зөв зохистойгоор ашиглах зорилгоор Сайн нарын Зөвлөл ба Намын Төв Хорооноос тогтоох нь:

Нэг. Их барилгын талаар,

1. 1945 – 1946 оны Их барилгын төлөвлөгөөнд оруулж Олзлогдсон цэргүүдийн хэргийг эрхлэх Ерөнхий газраар гүйцэтгүүлэх барилгуудыг дор жагсааваас;

1. Улсын дээд сургуулийн сурагчдын байр
2. Улсын дээд сургуулийн багш нарын байр
3. Улсын дээд сургуулийн хүн

ба мал эмнэлгийн анатомийн байшин

4. Улсын дээд сургуулийн Мал эмнэлгийн газар
5. Шинжлэх ухааны хүрээлэнгийн Улсын номын сан – ном судар агуулах газар
6. Улсын Хөгжимт драматик театр
7. Засгийн газрын байшин
8. Хотын зочид буудал
9. Шинэ хүчний дээд сургуулийн байшин
10. Кинотеатрын шинэ барилга
11. Гар үйлдвэрийн оёдлын фабрикийн барилга
12. Кобмен зуух
13. Аж үйлдвэрийн комбинатын клуб
14. Уран сайхны сургуулийн үзэсгэлэнгийн том тасалгаатай байшин
15. Волцов тээрэм
16. Орон сууцны барилга

2. Олзлогдсон цэргүүдийн хэргийг эрхлэх Ерөнхий газраас 1945 – 1946 онд эхний ээлжинд оруулан барих барилгуудыг жагсаан тодорхойлбоос;

а. 1945 оны дуусаагүй барилгууд

1. Улсын дээд сургуулийн хоёрдугаар ээлжийн барилга (хичээлийн байшин, уурын зуухны газар, туслах станц)
2. Гучдугаар барилгыг бүх туслах байшин барилгын хамтаар
3. Шинэ хүчний дээд сургуулийн дүнзэн байшингууд
4. Дотоод яамны нэгдүгээр хэлтсийн 2 байшин
5. Төв эмнэлгийн каналжуулах байшин
6. Хотын захиргааны сууц
7. Биогийн завод

б. 1946 оны төлөвлөгөөнд оруулан баталсан шинэ барилгууд

1. Улсын төв театр
2. Хотын зочид буудал
3. Шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан судар агуулах газар
4. Орон сууцны байр 4
5. Шинэ хүчний дээд сургуулийн барилга

б. Кобмен зуух

в. Хоёр айлын сууц бүхий дүнзэн байшин 40 -г модон дотортой хийж бэлтгээд жинхэнэ барих газарт тээвэрлэж авчрах болно.

3. Барилгыг хугацааг богиносгож дараа жилд шилжих барилгын тоог хорогдуулах зорилгоор бүх барилга дээр хоёр ээлжийн ажиллагааг зохиож, барилга бүхний талаар барилгын ажлыг хийх тухай Олзлогдсон цэргийн хэргийг эрхлэх Ерөнхий газраас зохиосон бөгөөд Улсын төсөв газраас баталсан графикайн ёсоор ажиллах байрыг дээд хэмжээгээр нягтруулахыг Олзлогдсон цэргийн хэргийг эрхлэх газарт үүрэг болгосугай.

Хоёр. Улаанбаатар хотыг сайжруулах талаар

1. Хотын дотор барилга барих явдлыг Сайд нарын Зөвлөлөөс баталсан Улаанбаатар хотын төв хэсгийн ерөнхий төлөвлөгөөний ёсоор гүйцэтгэсүгэй.

2. Айлын жижиг сууц хувийн байшин зэргийн бүх жижиг барилгыг Хотын зургийн гадна талд бариулж байсугай.

3. Хотын засмал төв зам, төв талбай, Мартын наймны гудамж, мөн Дээд сургуулийн гудамжнуудад хэрхэн ямар барилгуудыг бариулах тухай төлөвлөж дээд дурдсан бүх барилгыг

барих газраа Улсын төлөвлөгөөний газар лугаа хамтран 1945 оны 12 дугаар сарын нэгний наана боловсруулан тогтоож Сайд нарын Зөвлөлд оруулан батлуулахыг Хотын захиргааны зарга н.Багаад үүрэг болгосугай.

4. Засмал зам тавих тухай

Улаанбаатар хотын төв талбай , Лениний нэрэмжит гудамж , Мартын Уаймны гудамжуудыг тэгшилж тэдгээрийг 1946 онд асфальтлах явдалд бэлтгэх ажилд орохыг үүрэг болгосон

5. Улаанбаатар хотын Сэлбэ голд гүүр тавих

6. Улаанбаатар хотод усан цорго тавьж, каналжуулах барилгыг хийх талаар мэргэжилтэн урин ирүүлж, түүний зураг төлөвлөгөөг хийх,

Гурав. Барилгын материалын талаар

1. Олзлогдсон цэргүүдийн хэргийг эрхлэх Ерөнхий газраас 1945 – 1946 онд үйлдвэрлэн бэлтгэх орон нутгийн барилгын материалын программыг тогтоох, Үүнд;

а. Туйпуу

б. Шохой шатаах

в. Албестр

г. Ваар

д. Модон материал гэх мэт

2. Олзлогдсон цэргүүдийн хэргийг эрхлэх ерөнхий газрын мэдэлд шилжүүлэн буй бүх мэргэжилтний эзэмшиж байгаа орон сууцыг тусгай шийдвэр гартал хэвээр хэрэглүүлсүгэй.

Ерөнхий сайд, Улсын шалгарсан хошой баатар маршал Чойбалсан

Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Цэдэнбал” хэмээжээ.

Ийнхүү 1950 иад он болоход БНМАУ-ын нийслэл Улаанбаатар

хотын төв хэсэг дараах байдалтай сүндэрлэн боссон байна. Үүнд, хотын төв талбай цардмал хучилттай болж, гол дунд нь Жанжин Д.Сүхбаатарын морьтой хөшөө босжээ. Сүхбаатарын талбайн зүүн хойно Монгол Улсын Их Сургуулийн байр, түүний баруун талд 72 айлын орон сууц, талбайн зүүн хэсэгт Улсын төв театрын барилга (тэр үед одоогийн Дуурь бүжгийн театрыг ийнхүү нэрлэж байсан бололтой), түүнээс урагш Гадаад явдлын яамны байшин, Төв Клиник, түүний зүүн талд нэгдүгээр амаржих газар, Төв талбайн баруун өмнөх хэсэгт Улсын нийтийн номын сан, талбайн баруун талд Элдэв-Очирын нэрэмжит кинотеатр, Алтай зочид буудал (Улаанбаатар хотын засаг даргын тамгын газар), хоймор талд нь Засгийн газрын ордны барилга баригдсан байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвийн хэсгийн ерөнхий дүр төрх тэртээ 1940 оод оны сүүлч, 1950-

иад оны эхээр буй болоход Монголд ирсэн Олзлогдсон япон цэргүүдийн оролцоо, хувь нэмэр багагүй байсан нь түүхэн баримт, дурдатгалаас тодорхой байна.

Ийнхүү Тасрангийн Бавуудорж гуайн бичиж үлдээсэн дурсамжийг 2012 онд хэвлэгдсэн доктор Ч.Дашдаваагийн “Японы олзлогдогсод Монголд”, 2018 онд хэвлэгдсэн доктор Ж.Урангуа, Б.Эрдэнэбилэг нарын “Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд” номонд ашиглаагүй байгаа тул энэхүү энэхүү Т.Бавуудорж гуайн дурдатгал нь 1930-аад оноос 1940 хэдэн оны үеийн Монголын түүхийн зарим хуудсуудыг тодруулахад чухал ач холбог бол бүхий эх сурвалж даруй мөн хэмээн үзэж, судалгааны эргэлтэд оруулж буй билээ.

Ном зүй:

1. МАХН-ын архив ф.4, д.12, х.н.31 х.112- 114
2. МАХН-ын архив ф.4, д.12, х.н.31 х.114 –119
3. МАХН-ын архив ф.4, д.12, х.н.31 х.141 - 149
4. Дотоод Явдлын Яамны Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газрын даргаар 1945-1948 онд ажиллаж байсан Тасрангийн Бавуудоржийн дурдатгал
5. О.Батсайхан “Олзлогдсон япончууд Монголд” - “Nihon to Mongoru” Number 110, March of 2005 (Japanese) 56-72 дахь тал
6. Ч.Дашдаваа Японы олзлогдогсод Монголд УБ., 2012.
7. Ж.Урангуа, Б.Эрдэнэбилэг Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд, УБ., 2018.
8. Л.Дүгэрсүрэн Улаанбаатар хот (1921 -1940)., УБ.,1963 он, 78 дахь тал

T.Bavuudorj: About the names written in kanji on the nail plates of Japanese captivated soldiers

Batsaikhan Ookhnoi

Sc.D

Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,

Ulaanbaatar, Mongolia

batsaikhano@mas.ac.mn

Abstract: *After World War II there were around 12,000 Japanese personnel in the Mongolia interned to work in labor camps as POWs, which were sent from the Soviet Union. Of them, it is estimated that around 1500 died in captivity.*

But at this time, from October 1945 to February 1948, Mr. Tasran Bavudorj, who worked as the head of the Department of Correctional Camps and Prisons of the Ministry of Internal Affairs and the first secretary of the Party Committee of the Ministry, wrote his memoirs in 1989-90, and given to me. In his memoirs, he wrote down some very interesting facts about some of the complicated issues of Mongolian history in the 1930s, such as the 1932 “Rebellion of the Monks”, about Marshal Demid, and Marshal Choibalsang’s order to reveal himself and about Japanese POWs in Mongolia.

As noted in the memoirs of T.Bavudorj, when the captured Japanese soldiers returned to their homeland, Major Ishii, the head of the Japanese POWs camp, taking white bag, where he “cut off the thumbs of the dead soldiers and wrote down their names, surnames, ages, and regions.”

We assessed the memoirs of the T.Bavudorj, described a new findings of the Mongolian history in 1930-40s, and suggested to implement new source for the research of Mongolian history.

Key words: *Japanese POWs, World war II, T.Bavudorj, Mongolia, Soviet Union, Japan*

<i>The day of submission:</i>	<i>2022.11.20</i>
<i>Completion of review:</i>	<i>2022.11.21</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2022.11.22</i>